

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН  
2024 ОНЫ 2 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2024 оны 3 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар02

“ГТХЗНТ” УТУГ

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТУГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн батлуулсан нэгжүүдийн 2 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажил	Үүнээс							Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%	ХБ	
ЗСХ	16	12	-	1	-	1	2	-	81.3
ТНУАСХ	26	24	-	-	1	-	-	-	94.2
ГХБАБМХ	6	6	-	-	-	-	-	-	100
<b>Дүн</b>	<b>48</b>	<b>42</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>90.6</b>

**Дүгнэлт**

2 дугаар сард төлөвлөсөн 48 ажлын 87.5 хувийг бүрэн хэрэгжүүлсэн, 10.4 хувийг хэрэгжүүлж дуусаагүй, 2.1 хувийг өөр ажилтай хамт тайлагнасан байна.

Захиргаа, санхүүгийн хэлтсийн төлөвлөгөөнд тусгагдсан “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулж батлуулах”, “Албан тушаалын тодорхойлолтыг батлуулах” ажлууд хийгдээгүй (тасарсан 0%), “Төвийн дотоод үйл ажиллагаанд мөрдөж буй эрхзүйн 5 баримт бичгийг нэгтгэж боловсруулах” ажил хэрэгжилт хангалтгүй 30%-тай байна.

Тайлант сард хуралдсан Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаанаас нийт 5 үүрэг даалгавар өгсөн бөгөөд үүрэг даалгаврууд 100% биелсэн байна.

Тайлант сард нийт 23 хариутай бичиг бүртгэгдэж, 14 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж 2 албан бичигт хариу өгөөгүй, шийдвэрлэгдэж байгаа 7 бичиг тус тус байна.

2024.03.01-ний өдрийн байдлаар шийдвэрлэх хугацаа шийдвэрлэх хугацаа тав хоног хэтэрсэн 1, долоо хоног хэтэрсэн 1, шийдвэрлэх хугацаа заагаагүй ч системд бүртгэгдээд хариу өгөөгүй 25 хонож буй 1 бичиг тус тус байна.

Цагаан сарын баярын өдрүүдээр хариуцлагатай жижүүр ажиллуулсан тайланг ЗТХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газарт 2024.02.24-ний дотор, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг яамны Хуулийн хэлтэст 2024.02.22-ны дотор, Хүсэлт уламжлах тухай (Монгол Улсад бүртгэлтэй төмөр замын компани, нийт хөдлөх бүрэлдэхүүний судалгаа) албан бичигт тус тус хариу өгөөгүй байна.

2024.03.01-ний өдрийн байдлаар төвөөс хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, түрээслэгч болон суурь бүтцүүд явуулсан нийт 23 бичгийн хариу ирээгүй байна. Үүнд, ГХБАБМХ-ээс явуулсан 7, ТНУАСХ-ээс явуулсан 16 бичигт хариу ирээгүй буюу 2-25 хоногоор саатаж байна.

### **Санал зөвлөмж**

1. Шинээр баталсан Баримт нягтлан шалгах комиссын дүрмийг гишүүдэд танилцуулж, архивын үйл ажиллагаанд мөрдүүлэх;

2. 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан төвийн архивт заавал шилжүүлэх санхүүгийн, захирлын шуурхайн, хэвлэл мэдээллийн, сургалтын, нэгдсэн технологийн горимын төслийн, Койка төслийн, хөдлөх бүрэлдэхүүний дугаар олголт, гэрчилгээжүүлэлттэй холбоотой баримтыг хариуцсан ажилтнууд бүрэн бүрдэлтэй архивт хүлээлгэн өгөх;

3. Архивын ерөнхий газрын даргын 2023.11.23-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар баталсан Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтыг БНШК-ын бүрэлдэхүүн судалж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх;

4. Үлгэрчилсэн жагсаалтад баримт бичгийн хадгалах хугацааг тодорхойлох талаар холбогдох зүйл, заалт байхгүй бол төвийн онцлог чиг үүргийг тусгасан баримт бичгийг "Байгууллагын баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт"-д оруулж БНШК-ын хурлаар хэлэлцэж төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлсний дараа төвийн захирлаар батлуулах;

5. 2024 хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын төсөл боловсруулах, БНШК-ын хурлаар хэлэлцүүлэх, батлуулах;

6. Төвийн цахим хуудсыг яаралтай ажиллуулж нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангах;

7. Зурмаг загварчлалын, ашиглалтын ажлын нормчлолын, стандарт, хэмжил зүйн мэргэжилтний албан тушаалын сул орон тоог зарлах, Ажилтан сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулах, албан тушаалын тодорхойлолтын шаардлагад нийцсэн, шалгуур хангасан иргэнийг томилох;

8. Нэгдсэн зурмагийн хэрэгжилтийн дүнгийн хурал зохион байгуулж, зурмагийн тасалдлын зорилтот үзүүлэлтийг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, тээврийн тоон болон чанарын үзүүлэлтүүдийг сайжруулах арга хэмжээг тохиролцох;

9. Шинэчлэн батлагдсан хуулийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн орон тоо, бүтцийг бэлтгэх;

10. Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын нэмэлт өөрчлөлтийн санал, Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг хөтлөх, боловсруулах заавар, Монгол Улсын төмөр замын сүлжээнд галт тэрэгний дугаарлалт хийх заавар, Өртөөний технологийн горим боловсруулах зааврын төслийг боловсруулах;

11. Хоног, долоо хоног, сар, улиралд Яам, төрийн байгууллагыг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр шуурхай хангах, эдгээр мэдээллийг хүргүүлэх механизмыг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

12. Хөдлөх бүрэлдэхүүний улсын нэгдсэн тооллого зохион байгуулах, бүртгэл хийх, хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд төвийн дүрэм нэмэлт оруулах саналыг ЗТХЯ-нд хүргүүлж шийдвэрлүүлэх;

13. ТР ТС 001/2011 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын техникийн стандартыг орчуулан боловсруулах ажлыг эхлүүлэх;

14. Нэгдсэн технологийн горимыг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах, суурь бүтцүүдэд 2024.02.23-ны өдөр хүргүүлсэн 122, 123, 124, 125 тоотын хариуг авч шийдвэрлэх;

15. Авлига ашиг сонирлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах, Ажилтан сонгон шалгаруулах журам, Инженер-ирээдүй хөтөлбөр, Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг, Шагнал олгох журам, Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг нэгтгэж, шинэчлэн батлуулах;

16. Чиг үүргийн дагуу зохион бүрдүүлж, холбогдох байгууллагад хүргүүлсэн бичгийн араас хөөцөлдөж ажиллах, хариуг нэхэх, төлөвлөгөө тайланг үг үсэг, найруулгын алдаагүй тайлагнаж байх.

**ТАНИЛЦСАН:**

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ

А.БУЯННЭМЭХ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

ТНУАСХ-ИЙН ДАУТОГ

Ж.АЛИМАА

**БОЛОВСРУУЛСАН:**

ХШҮМ

*Э.Осоржамбаа*  
III/06.

Э.ОСОРЖАМАА